МЭДЭЭ · 2022 оны 4-р сарын 28

ХУУЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН АЖЛЫН УЯЛДАА ХОЛБООГ САЙЖРУУЛАХАД АНХААРЧ БАЙНА



Налайх, Багахангай дүүргийн прокурорын газраас тус дүүрэг дэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн шийдвэр гүйцэтгэгч, Цагдаагийн хэлтсийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан албан тушаалтан, хороодын хэсгийн байцаагч нарт "Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа", "Зорчих эрхийг хязгаарлах ял, түүнд тавих хяналт" сэдэвт сургалт хийлээ.

Энэхүү сургалтыг хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Цагдаагийн байгууллагын уялдаа холбоог сайжруулах, ажилтан, алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор зохион байгуулсан байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2506